

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

XIX ЗУУНЫ ТӨГСГӨЛ ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН ЗАРИМ БИЧИЛ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН АСУУДАЛД

Г.Нарантунгалаг

Түлхүүр уг: Улгэр өгүүллэг, "Үг" зохиол, "Яриа" зохиол

Монголын эртний болон орчин үеийн уран зохиолын түүхийг уран зохиол судлаачид ул суурьтай судлан шинжилсээр иржээ. Баялаг хэрэглэгдэхүүн бүхий Монголын уран зохиолын судалгаанд зохиолын төрөл ба зүйлийн судалгааг нэлээд хийсэн ч тэдгээр төрөл зүйлийн завсар хооронд судлагдаагүй жижиг зүйлүүд байсаар ирэв. Мөнхүү Монголын уран зохиолын хөгжлийн нэгэн онцлог ўе болох XIX зууны төгсгөл, XX зууны эхэн үеийн (нийгмийн шилжилтийн ўе буюу хамжлагат ёсны төгсгөл, ардын хувьсгалын эхэн ўед өргөн дэлгэрсэн) дурсгалууд дотор "яриа" хэлбэрийн өвөрмөц зохиомж бүхий төрөл зүйл бие даан хөгжсөн бөгөөд олон талаараа анхаарал татсан сонирхолтой судалгааны сэдэв юм. Энэхүү өвөрмөц жүжиглэлт төрөл зүйлийн талаар дотоодын болон гадаадын эрдэмтэд анхаарч судалсан зүйл нэлээд бий. Тэдгээрийг тодруулбал:

Академич Д.Цэрэнсодном "Монгол уран зохиол" (XIII-XX зууны эх) хэмээх бүтээлдээ "XIX зууны үеийн зохиолчдын бүтээлд Өнчин янзаганы уг, Тарваганы уг, Хөгшийн үнээний уг, Хонь ямаа үхэр гурвын гэлэн тойнтой хүүрнэсэн яриа, Хаврын хайлаад урсааж байгаа цасны уг, Салхинд хийссэн хамхуулын уг гэх мэт амьтай, амьгүй амьтан юмын санааг үгээр илэрхийлсэн богиновтор зохиол олон гарчээ. Ийм зохиолыг судлаачид 'Үг зохиол' гэж нэрлэж байна" (1987:395) хэмээн "Үг" болоод "Яриа" зохиолыг нэгтгэн үзсэн бол шинжлэх ухааны доктор Д.Ёндөн "Үг хэмээх зохиолын тухай" өгүүлэлдээ "Бид Үг-ийн тухай авч ярихдаа одоогоор хуульч Сандаг, Ишсамбуу нарын бүтээлийг эш татахаас онц их хэтрэхгүй байгаа юм. Ер нь XIX зууны ўед олон Үг бичигдсэн нь зохиолын энэ төрөл зүйлийн хөгжилд гарсан цэцэглэлтийн ўе мөн. Харин уг төрөл зүйл хэзээ, хэрхэн үүссэнийг тодорхойлох баримт бидэнд олдоогүй байна. Юу ч гэлээ эл зорилгын үүднээс шинэ соргог Үг-ийг эртний уран зохиолын баялаг сан болоод аман зохиолын арвин ёв дундаас эрж сурвалжлах нь чухал. Ингэж узвэл Монгол ардын аман зохиолд Үг-тэй төстэй зохиол байдаг юм" (2012:112) гээд "Үг нь заавал шүлэглэсэн хэлбэртэй бус бас хүүрнэл хэлбэр бүхий байж болдог бололтой юм. Ц.Дамдинсүрэнгийн "Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив"-д орсон "Хэрээ шаазгай хоёрын хэлэлцэн үгс" мэтийн зохиол бол хэдий үргэлжилсэн үгээр боловч угтаа "Үг" зохиолын нэгэн хэлбэр гэж үзмээр байна" (Мөн тэнд) хэмээн "Үг" зохиолыг хүүрнэл болоод шүлэглэсэн хэлбэртэй байж болох талаар санал дэвшүүлсэн бол академич П.Хорлоо "Хуульч Сандаг ба түүний бүтээл" өгүүлэлдээ "Сандагийн бүтээлүүд нь Монголын орчин үеийн хошин шог зохиолын эх уламжлал болсон юм. Сандаг яагаад ёгт хошин шог зохиолыг бүтээх болов гэвэл гурван үндсэн шалтгаан байна. Үүнд:

Нэгдүгээрт: тухайн үеийн нийгэмд хурцдаж байсан ноёлогчдын харгис бурангуй явдлыг шүүмжлэн жирийн хүмүүсийн эрх чөлөөний байдлыг хүсэн тэмүүлэх сэтгэлийг илрүүлэхэд хошин шог зохиол бол хамгийн хурц төрөл зүйл болсон учраас,

Хоёрдугаарт: бодит үнэн байдлыг шууд шоглон шүүмжлэхэд тэр цагийн нийгмийн байдалд зохицуулан, адгуусан амьтнаар төлөөлүүлэн далдуур шүүмжлэх шаардлагад ётг шоглол хамгийн зохистой хэлбэр байсан учраас,

Гуравдугаарт: лам ноёдын бузар булаг явдлыг олон түмэнд илт жигшүүлэхэд хамгийн хурцаар нөлөөлөх зүйл нь шог зохиол болсон учраас Хуульч Сандаг хошин шог зохиолыг бүтээсэн байна. Ийм болохоор Хуульч Сандаг бол орчин үеэ хурцаар тусгасан утга зохиолын нэг том төрөл зүйлийг бүтээсэн нэрг зохиолчийн нэг юм” (1968:58) гээд “Үг” ба “Яриа” зохиолыг ерөнхийд нь “шог шүлэг”-ийн төрөл хэмээн узсэн юм. Профессор В.Хайссиг “Монголын утга зохиол” бүтээлдээ “Лам нарын зохисгүй явдлыг “Тоглоом болгон шүүмжилсэн хулганын үг” буюу “Хувраг, хулгана хоёрын өгүүлэл” нэрг хулгана, хувраг хоёрын харилцан ярианы хэлбэрээр шүүмжилжээ. Энэ шүүмжлэн элэглэсэн харьцуулал, сургаал нь “Үг” гэдэг тусгай ай болж хөгжив” (1970:278) гээд мөн *Zur Überlieferung der Üge-Dichtung [Үг шүлэглэлийн уламжлал]* өгүүлэлдээ “Тоглоом болгон шүүмжилсэн хулганын үг”, “Хувраг, хулгана хоёрын өгүүлэл”, “Сэрэмж үгүй хэмээх уужим ойтой лам сэргэлэн ухаант алтан тургалдай шувуу холбон шүлэглэсэн үлгэр”, “Хайрагч, хун шувуу хоёрын хэлэлцсэн үгс” зэрэг зохиолыг хэвлүүлсэн (Heissig, 1967) байна. Академич Ц.Дамдинсүрэн: “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив” (1959), “Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд” (1987) бүтээлүүддээ “...энэ үед “Үг” гэсэн ерөнхий нэргтэй, нэг хэсэг зохиол ард түмний хамгийн гүнд, нийгмийн хамгийн олон анги давхаргынхан дунд гараас гар дамжин хуулагдаж, тэр байтугай сүм хийдийн барханд төвд, монгол хэлээр хэвлэгдэж байжээ” хэмээн узсэн нь сонирхолтой бөгөөд “Үг” гэсэн ерөнхий нэргтэй гэж зориуд тодотгосон нь “Үг”, “Яриа” гэх өөр зуураа ялгарал бүхий ганцаарчилсан ба харилцаа яриагар бүтсэн жижиг төрлүүд мэдэгдэхүйц хөгжиж, зааг ялгарал гарч байсныг харуулж байна. Эрдэмтэн С.Лувсанвандан: “Монгол өгүүллэгийн түүхэнд В.Инжиннашийн өгүүллэг гүн ухааны сэтгэлэг, нийгэм иргэний аяс, шүүмжлэлт хандлагаараа өвөрмөц юм. Хуульч Сандагийн “Үг” өгүүллэгт аман зохиолын нөлөө мэдэгдэм билээ. Ер нь Монголын үргэлжилсэн зохиолын жижиг төрөлд “Үг”, “Яриа” гэдэг сонин хэлбэрүүд бий” (1973:85) гээд эдгээр зохиолын хэлбэр, хэмжээ, төрөл зүйлийн хэв маяг, урлал зүйн өвөрмөц барил нь 1920-оод оны үеийн үлгэр-өгүүллэг, хошин болон шог өгүүллэгт цаашдаа уламжлагдсаныг тэмдэглэсэн бий. Үүнээс сонирхолтой нь “Үг” болон “Яриа” зохиолын зааг ялгааг онцлон тодорхойлсон явдал төдийгүй “Үг” ба “Яриа” зохиолыг тус тусдаа бие даасан зүйл (жанр) гэж үзэж байсныг илтгэдэг билээ. Судлаач Г.Жамсранжав “Анхны алхам” (1969), “Шинэ замаар” (1978) судалгаа - шүүмжлэл - уран зохиолын хөгжлийн талаарх тойм бүтээлүүддээ “Яриа”-г “Үлгэрээс өгүүллэг тийш” хэмээн тусгай нэг бүлэг болгоод Г.Навааннамжилын “Уран өгүүллэлт хулгана зурмаар утга учралт үгсийн өгүүлэлдээ”, С.Буяннэмэхийн “Моторын тэрэгний хэрүүл”, “Гурван дугуйтын зовлон” зохиолуудыг үлгэрийн хэв маягтай адилтгасан аж. Судлаач Ч.Жачин: “Монголын орчин үеийн уран зохиолын түүх-І”, “Хэл зохиол судлал” сэтгүүлийн 1986 оны дугааруудад “Үг” ба “Яриа” зохиолыг үлгэр өгүүллэгийн төрөл зүйлд хамруулан судалж “Үлгэр-өгүүллэгийн өгүүлэмжид харилцан яриа ашиглах, толгой холбон бичих (Г.Навааннамжил “Хулгана зурмын яриа”) баатрын дотоод сэтгэлийг шүлгээр илэрхийлэх (Д.Чимэд “Эрхэм баян эрдэм бичиг”, “Ангир шувуу”) гэх мэт онцлог зүйлс ажиглагдаж байна” (1985:292) хэмээгээд “...Хорин хэдэн онд үлгэр-өгүүллэгийн зэрэгцээ уран сайхны өгүүллэг гарч байв. Үүнд: Шагдарсүрэн “Гайхамшигт байдал” (1926), С.Буяннэмэх “Ядуу нэгэн хоньчин”, Дашдэмбэрэл “Мухар бишрэлийн эндэгдэл”, Д.Чимэд

“Харгисын ярилцаан”, “Феодалын хөрөнгө”, “Баячууд баяргүй үгс хэлэлцэнэ”(1929) зэрэг өгүүллэг болно (Мөн тэнд) хэмээн цэвэр “Яриа” хэлбэрийн зохиолыг уран сайхны өгүүллэг хэмээн үзжээ. Судлаач Г.Ринченсамбуу: “Аман зохиол, хуучин уран зохиолын шүлэглэлийн олон хэлбэр үг, яриа, үлгэр, домог, туж, шастир, судар болон харилцаа дууны зэрэг төрөл хэлбэрүүд нь шинэ уран зохиолд таатай сайхан нөлөө үзүүлжээ. Уран сайхны дүрийн тогтолцоо, бүтэц зохиомж, өгүүлэмжээрээ хуучин уран зохиолын үг, яриа, үлгэр гэсэн нэртэй зохиолууд нь өгүүллэгтэй адил төстэй байдаг” (1992:7) гэж тодорхойлжээ. Шинжлэх ухааны доктор Л.Хүрэлбаатар: “Үг” зохиолын гол төлөөлөгчдийн уран бүтээлийн талаар “Огторгуйн цагаан гарди-I” (1996) “Огторгуйн цагаан гарди-II” (2008), “Алтан хурдэн” (1995), “Сайн угсийн сан” (1995) бүтээлдээ “Үг”, “Яриа” зохиолын төвд монгол хэлээр бичигдсэн зарим дурсгалуудыг задлан шинжилж, тайлбартай хэвлүүлсэн нь эл судалгаанд хамрагдсан юм. Мөн судлаач Г.И.Михайлов “Орчин үеийн Монголын утга зохиолын түүхэн найруулал” номдоо “Яриа” зохиолын талаар тусгайлан дурдаагүй боловч XIX зууны үеийн зохиолчдоос Сандаг, Гэлэгбалсан нарыг онцолж, XX зууны эхэн үеийн уран зохиолыг “Монголын ард түмнээс хөрөнгөтний бус хөгжлийн замаар хөгжихийн төлөө феодализмтай тэмцсэн үеийн утга зохиол” (1921-1940) гэх хоёрдугаар бүлэгт хамруулаад Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Д.Цэвэгмид нарын бүтээлийг задлан шинжилсэн юм. Судлаач “Монголчуудын утга зохиолын өв” номдоо “Гэмшил”-ийн төрөл зүйлд “Үг” зохиолыг” (1968:87) хамааруулсан нь анхаарал татаж байна. Монгол утга зохиол судлагч, профессор Л.К.Герасимович “БНМАУ-ын утга зохиол” (1921-1964) ганц сэдэвт зохиолдоо: Социалист реализм “1935 оны үед Монголын уран зохиолын арга болж бүрэн төгс бүрэлдэн хөгжөөгүй, харин нийгэм журамт ахуйч, үзлийн хөгжлийн нэгэн шат болох хувьсгалт ахуйч үзлийн хэмжээнд оршиж байсан” (1965) хэмээн дүгнэж, II дэвтрийн “Хүүрнэл зохиолын найруулал” хэмээх бүлэгтээ “Орчин үеийн монголын хүүрнэл зохиолын бүрэлдэн тогтох үйл явцад монгол ардын аман зохиолын төрөл зүйлүүд онцгой үүрэгтэй байлаа. 1920-30-аад он 1940-өөд оны эхний хагасын Монголын уран зохиол ардын аман зохиолын уламжлалын хүчтэй нөлөөн дор байв. Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, С.Буюннэмэх, М.Ядамсүрэн нар болон бусад зохиолчид ардын аман зохиолыг шууд дуурайн шинэ агуулга, шинэ үзэл санаа шингээж бичсэнээр аажмаар цоо шинэ төрөл хэлбэрт шилжив” (1989) гэж дүгнэжээ. Энэ нь “Яриа”, “Үг” хэмээх аман ба бичгийн хослол шинжтэй завсрлын бичил зүйлүүдийн хөгжлийн үе шатны онцлогийг гүнзгийрүүлэлгүй орхисон тал харагддаг. Доктор Х.Сүглэгмаа “Монголын уран зохиол дахь “Үг” зохиолын төрөл зүйл” ганц сэдэвт зохиолдоо “Үг” зохиолын судалгааг гүнзгийрүүлжээ. Судлаач номын удиртгал хэсэгт “Үг” зохиолын төрөл зүйл монголын уран зохиолд эртний уламжлалтайг судлаачид өөрсдийн бүтээлдээ ямагт тэмдэглэсээр ирэв. Хүн ба адгуус амьтан, амьгүй эд юмын хэлсэн үг, хэлэлцсэн яриа, өөр хоорондын маргаан мэтгэлцээний хэлбэр маягаар зохиомжилж, ертөнцийн алив үзэгдэл, эд юмс, түүний мөн чанар, жам ёсыг нээж, түүгээрээ ертөнцийн явдал үйл, зан суртахуун, нийгэм цаг үеийг зөв нээхэд чиглэсэн онцлог бүхий ийм хэлбэрийн зохиолын талаар үе үеийн эрдэмтэн судлаачид үнэтэй, сонирхолтой эрэл хайгуул хийн, баримтаар нээн тайлж санал дүгнэлтээ дэвшүүлж ирэв. Энэ нь “Үг” зохиол төдийгүй уран сайхны бүтээлийн төрөл зүйлийн судалгаа, тэдгээрийн нарийн зааг ялгааг тодорхойлох, нэгдсэн дүгнэлт хийх, өөр хооронд нь холbon харьцуулж, өвөрмөц онцлогуудыг тодорхойлон тогтооход онцгой ач холбогдолтой юм.

Өрнө, Дорнын утга зохиолд буй зарим жишээ баримтад тулгуурлан, тухайн улс орны эрдэмтэд “Үг” зохиол гэх эн зүйл уран зохиолын ямар зүйл болох талаар хоорондоо нийтлэг төсөөлөлтэй байхын зэрэгцээ төстэй тал хийгээд бүр эсрэг янз бүрийн саналуудыг судалгаандаа дэвшүүлсэн бөгөөд агуулга, хэлбэр, зохиомжийн хувьд эл төрөл-зүйлд хамаарах зохиолуудын

нэрээс ажиглахад “Үг”, “Яриа”, “Үлгэр” зэрэг ялгаатай нэр томъёогоор өөр өөрөөр бичиж...” (2005: 5) буйг тэмдэглэсэн нь эдгээр бичил зүйлийн тус тусын онцлогийг тодорхойлон тогтоох хэрэгцээ буй болсныг харуулж байна. Тэрээр “Яриа” зохиолын тухайд “Хувраг нохой хоёрын харилцан яриа маягаар зохиомжилсон энэ зохиол нь ийнхүү “Үг” зохиолын төрөл зүйлийн дотор цөөн үзэгддэг “Яриа”-н хэлбэрээр бичигдсэнээрээ онцлог” (2005:29) болохыг ажиглаж, “Баруун Европт ихэд дэлгэрсэн ийм бүтээл бол “Аргат сэргэлэн Ренар үнэгний тухай үлгэр” гэжээ. Энд монгол хүмүүн бидний амьдралд ч цаг үргэлжид тохиолдож байдаг башир, хуурмаг зан суртахуун, зохисгүй хэрэг явдууд, амьдралын олон янзын бэрхшээл зовлонг өөрийн арга уран нарийн ухаанаар гэтлэн давж, тэр бүрий адгуус амьтан өөр хоорондоо хүний хэлээр ярьж, маргаж мэтгэх, цэц булаалдах сурган номлох зэрэг нь хэдий үлгэрлэг шинжтэй ч “Үг” зохиолын хэв шинж, зан төрхийн уран сайхны нийтлэг загвар” шинжтэйг ажигласан бол, Оросын эрдэмтэн Ю.М.Осипов “Тахиа үнэгний тухай үлгэр” хэмээх бүтээлийг “Үг” зохиолын төрөл зүйлд агуулга хэлбэрийн хувьд ойтсон бүтээл зэргээр тодорхойлсон байдаг” (2005:10) гэжээ.

Доктор Б.Баянаа зарим “Үг” зохиолууд нэлээд шинжээрээ ёгт үлгэртэй төстэй байдгаас нэг хэсэг судлаач, тухайлбал Г.Жамсранжав, П.Хорлоо, Ш.Гаадамба нар ёгт үлгэрийн төрөлд хамааруулан үзэж Агваанхайдавын “Хонь, ямаа, үхэр гурвын яриа”, “Урт үст Цэрэнпил хэмээх бандидтай тэмцсэн үг” зохиолуудыг жишээ болгосон бол Германы эрдэмтэн В.Хайссиг хэдийгээр “Үг гэх цэцэн цэлмэгээр шүлэглэсэн зохиолыг хэлнэ” гэж тодорхойлсон байгаа ч “Хувраг, хулгана хоёрын өгүүлэл оршив”, “Сээрэмж үгүй хэмээх уужим ойтой лам, сэргэлэн ухаант алтан гургалдай шувуу холbon шүлэглэсэн үлгэр”, “Хайрагч хун шувуу хоёрын хэлэлцсэн үгс” зэрэг зохиолыг “Үг” хэмээн үзсэн байна гээд тухайн үеийн жижиг хэлбэрүүд нийтэг шинжтэй байсныг жишээ баримтаар нотлон тайлбарласан нь анхаарал татаж байна.

Эрдэмтдийн бүтээлд нийтлэг ажиглагдсан санал дүгнэлт бол “Үг” болоод “Яриа” зохиолыг нэг төрөл зүйлд хамруулах, адилтгах эс бөгөөс үлгэр өгүүллэгт багтаах хоёр гол агуулгатай байна. Бидний үзэхээр эл хоёр төрөл зүйл тус тус харьцангуй бие даасан зүйл бөгөөд хөгжлийн явцад “Үлгэр”-ээс “Үлгэр өгүүллэг”, “Үлгэр өгүүллэг”-ээс өгүүллэгт шилжсэн бол “Үг”-ээс “Яриа” зохиол, түүнээс орчин цагийн жүжиглэлт богино хэлбэрүүд үүсэн драмын урлагт шилжсэн зүй тогтолцой хэмээн бид үзэж байна.

Монгол ардын аман зохиолын дайралцаа, үүдэн дарлагын үг зэрэг эртний уламжлалт ураглах ёсны зан үйл, цэцлэл маргааны аман зохиол болоод жүжиг наадмын аман зохиол нь их төлөв харилцан яриа хэлбэртэй байжээ. “Дайралцааны гол агуулга нь бие биетийг дайрч доромжлоход бус харин цэц билгээ сорьсон ухаан бодлын нөхөрсөг өрсөлдөөн учраас түүний гол хэсгийг оньсого тааврын чанартай илэрхийлэл хийгээд нөхөрсөг мэтгэлцээний өнгө аяс бүхий ярианы элементүүд голлон эзэлдэг онцлог бий. Иймээс эдгээр зүйлүүдэд ардын оньсого таавар, зүйр цэцэн үг тэргүүтнийг хэр зэрэг эзэмшилэний эрдэм чадлын сорилго шинжтэй байдаг. Иймд:

Хаднаасаа өндөр гэж

Энэнийг юугаар тайлна

Хабхас үгүй талбина гэж

Энэнийг юугаар тайлна

Хадам үгүй хүмүүн гэж

Энэнийг юугаар тайлна

Хазаар үгүй амьтан гэж

Энэнийг юугаар тайлна

Үүл үгүй бороо гэж

шишүү цэдэнийнхээ нэх

Энэнийг юугаар тайлна...

зэргээр мэтгэн асуухад:

Хаднаасаа өндөр гэж

Наран нэгээр тайлья

Хабхас үгүй талбина гэж

Нүд л нэгээр тайлья

Хадам үгүй хүмүүн гэж

Лам л хүнийг хэлдэг юм

Хазаар үгүй амьтан гэж

Хан гөрөөсийгхэлдэг юм” (АЖНАЗ, 1988:13)

гэх зэргээр ардын жүжиг наадмын аман зохиолын дотор тоглоом наадмын үг хэллэг томхон байрыг эзэлнэ. Мөн “Хоёр танил” хэмээх үгэн тоглоомоор наадахдаа нэг хүүхэд нь айлчин, бусад нь айлынхан болоод:

- Би та нарт өвчүү, гуя хоёр хоёр авч ирэх гэсэн юм
- Тэгээд аваад ирэхгүй яагаав
- Шар нохой, хар нохой хоёр булаагаад явчихлаа
- Шар нохой хар, нохой хоёр хаачсан бэ?
- Тэр хоёр нохой түлээчин дагаад явсаан
- Түлээгээ яасан бэ?
- Түлээ түймэрт шатсан...

зэргээр хариултыг асуулгаар мухарлан гартуулах, уг хэрэг явдлын логикийг алдагдуулахгүйгээр нөхөрсөг шог өнгө аястай болгон хэлэлцдэг бөгөөд энэ нь хүний аж төрөл, байгаль өргөнцийн юм үзэгдэл цугаар хоорондоо уялдаатай, “...нэг нь нөгөөгөө орлон төлөөлж байдгийг таниулан хүүхдийн уран цэцнээр маргах чадварыг дээшлүүлдэг байна” (Сампилдэндэв, 1984:83). Хүүхдийн тоглоом наадам нь зөвхөн баясуулан цэнгүүлэх учир холбогдолтой төдий биш хүүхдийн бие бялдар, оюун сэтгэхүйг хөгжүүлэх, ажил амьдралын дадал туршлагыг танилцуулах зориулалттай байдаг. Монгол ураглах ёсны зан үйлийг дагаж зохиогдсон янз бүрийн дайралцаа, мэтгэлцээ, цэц сорилгын өнгө аяс бүхий олон зуун бичил уран үг хэллэгүүд бий. Үүнээс жишээлбэл үүдэн дарлагын үгд:

Ураг биднийг ирэхээр дардаг үүд үү?

Өдөр болгон дардаг үүд үү?

Өнөөдөр биднийг ирэхээр дардаг үүд үү?

Ордог гардаг үүдийгээ

Онътой баганаар дардаг нь

Ямба уу?

Ёс уу?

хэмээхэд хүргэн тал:

...Тоонотой гэрийн үүдийг

Тостой хусан баганаараа дарж

Хадам ургийн та нарт хандаж

Хариу хэдэн үгийг хэлэх нь

Хэн хүний дур биш

Хавтгай монголын жам юм аа” (АЖНАЗ, 1988:13)

зэргээр хэлэлцэх бөгөөд энэ мэт олон тооны харилцаа яриа голлосон аман зохиолын төрөл зүйлс буй.

Монголын эртний уран зохиолд “Алтан ордны үйсэн дээрх бичиг”, “Чингисийн хоёр эр загалын тууж”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвүүний сэцэлсэн шастир” зэрэг сонгодог дурсгалууд болон XVIII-XIX зууны үе болж ирэхэд харилцан яриа хэлбэр зонхилсон бүтээл, нийтлэл элбэгшсэн төлөв харагддаг. Тухайлбал XIX зууны Монголын газар зүйч Тогмид 1874 онд зохиосон ертөнцийн тогтцын тухай “Замбутивийн асуудал” нэрт гар бичмэл бүтээлээ дан харилцаа яриа, мэтгэлээний хэлбэрээр бичсэн байдаг. Уг бүтээлд “Замбутив бөөрөнхий бөгөөд нэг хоногт нэгэнтээ өнхрөн, 365 хоногт төдий өнхөрсөөр нэгэн жилд нарыг нэгэнтээ тойрч гүйцдэг тухай хийгээд нар, сар, оддын тухай, Замбутивийн ихэнхийг ус эзэлдэг тухай, Замбутив яагаад бөөрөнхий болсон ба тэнхлэгээ эргэдгийн учир, нар ургах, жаргахын учир зэрэг танин мэдэхүйн олон чухал асуудлыг хөндөж өвгөн, хүүхэд хоёр харилцан ярилцсан байдлаар сонирхол татахуйц бичсэнээрээ онцлог юм” (Норовсүрэн, 2004:129-130). Энэ уламжлал XX зууны эхэнд үргэлжилж: “1910 оны үед одоогийн Дорноговь аймгийн нутагт Чагдар, Балдан-Осор гэх хоёр залуу “Ядуу банди, чөтгөр хоёрын яриа” нэрт хоёр зуу гаруй бадаг бүхий харилцан яриа-үзэгдлүүдийг жүжиглэж явсан тухай (1989:8-9) театр судлаач Э.Оюун тэмдэглэжээ. XVIII–XIX зууны бичгийн мэргэд хориглон шүүмжилсэн, харилцан бие биедээ зориулсан захия бичгийн зохиолуудыг ч энэхүү “Яриа” зохиолын өвөрмөц төрөл, бие даасан том хэмжээний бүтээл гэж болно.

Эдгээр уламжлалын үрээр монгол театр-жүжгийн урлагийн хөгжил нь нэгдүгээрт энэтхэг, төвд, хятадын жүжиг, ший янгуу, мөн ХХ зууны эхэн үеэс Орос ба Европын театрын урлагтай ойртон холбоотой хөгжсөн зэрэг гадаад нөлөөлөл байсан хэдий ч монгол үгийн урлагт үндэсний жүжиглэлт зохиолын төрөл зүйлүүд XIX зууны дунд үе, түүнээс ч өмнө ардын аман зохиолд эх сууриа тавьж, үндэсний аж төрөл, нийгэм соёл, хот суурин, хүрээ хийд, шашны бүжиг жүжиг дэлгэрсэн зэрэг гадаад нөлөөллөөс гадна үндэсний үгийн урлаг хөгжсөн “Үг”, “Яриа” /ярилцаан/ мэт жүжиглэл шаардсан зохиолоор дараагийн шатанд дэвших нөхцөлүүд бүрэлдсэн билээ. Аливаа жүжиг, драмын бүтээл бүтэх ёсон үндсэн арга “харилцан яриа” /дуулал/, -д суурилдаг бол нэг талын яриа буюу ганцаарчилсан яриа нь үгээр өчих, мэтгэх, маргах зэрэг харилцааны олон талт арга бөгөөд аль аль нь “Яриа”, “Үг”-ийн ялгарах гол онцлогийг тодорхойлогч элементүүд болно. Ер нь уран зохиолын бүх төрөл (туульс, уянга, жүжиг) хийгээд зүйлд нэг буюу хэд хэдэн /янз бүр/ биеэс харилцан өгүүлж, үйлдэх, эсхүл өөртэйгөө шууд ба шууд бус байдлаар хэлэлцэх ярианы элементүүд зонхилдог.

Энэ бүхнээс шалтгаалан зохиолын доторх ганцаарчилсан болон олон тооны дүр хооронд, эсвэл хэлэлцэгч баатар өөрөө өөртөө ярих, өчих, мөн бусадтай харилцах, гэмшил, үглэл, ганцаарчилсан ил яриа, дотоод ярианы маягаар өгүүлэх... зэрэг “ярих” өвөрмөц арга хэлбэрүүдийг ашиглан туурвиц зүйд уран сайхны үүргээр урт удаан хугацаанд ашигласан арга туршлагын цогц нь хоёр зууны заагт нэр бүхий бие даасан өвөрмөц ялгарал бүхий төрөл зүйлүүдийг бий болгожээ.

Энэнийг юугаар тайлна
Хадам угийн хүчүүв гэж
Энэнийг юугаар тайлна
Хэсээр угийн хүчүүв тэж
Энэнийг юугаар тайлна

тэд нэгдүүг дэхжүүлж
тэндүү нийцэл үүтонооб...
жийд захиалжид нэгдүү үүтонооб
жаднах тэви ят нийцүү нийцау
ан хөлөж тэндүү нэгдэл үүрийн

Summary

In previous studies, 'Word' and 'Dialogue' are considered to be either same genre or dissimilar one that have twomeanings within fairytale-stories. According to our study, these two genres are relatively independent of each other. During the process of development, 'Fairytale' shifted to 'Fairytale-stories' and 'Fairytale-stories' to 'Narratives' whereas 'Word' to 'Dialogue' which are a micro-genre of novels that transferred to modern drama.

Номзүй

АЖНАЗ - Ардын жусжиг наадмын аман зохиол. Эмх. боловс. удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв. Уб., 1988.

Герасимович Л.К. Литература Монгольской Народной Республики (1921-1964). Л. 1965.

Герасимович Л.К. Литература Монгольской Народной Республики (1965-1985). Л. 1991.

Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд. Уб. 1987.

Ёндөн Д. Үг хэмээх зохиолын тухай. Монголын соён гэгээрүүлэгч Эрдэнэ мэргэн бандида Агаашишамбуу. Уб., 2012.

Жачин Ч. Өгүүллэг. Монголын орчин үеийн уран зохиолын түүх-I. Уб., 1985, х.284-301.

Лувсанвандан С. Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд. Уб. 1973.

Михайлов Г.И. Литературное наследство монголов. М., 1968.

Норовсүрэн Л. Монгол нийтлэл. Уб., 2004.

Оюун Э. Монголын театрын түүхэн замнал. Уб., 1989.

Ринченсамбуу Г. Утга зохиол урлагийн зарим асуудал. Уб., 1992.

Сампилдэндэв Х. Орчин үеийн аман зохиолын зарим асуудал. Уб., 1984.

Сүглэгмаа Х. Монголын уран зохиол дахь "Үг" зохиолын төрөл зүйл. Уб., 2005.

Хайссиг В. Монголын утга зохиол. Орч. Ц.Цэвэлмаа, Д.Ёндөн. Хэл зохиол судлал. Т-XII, fasc. 10. Уб., 1970.

Хорлоо П. Хуульч Сандаг ба түүний бүтээл. Хэл зохиол судлал. Т-V, fasc. 4. Уб., 1968, х.57-65.

Хүрэлбаатар Л. Оришил. Монголын уран зохиолын дээжис. Уб., 1995, х.17-28.

Цэрэнсодном Д. Монголын уран зохиолын товч түүх (XIII-XX зууны эхэн). Уб., 2002.

Heissig W. Zur Überlieferung der Üge-Dichtung. I - Vier unhekannte Üge. Zentralasiatische Studien. Bd.1. 1967, SS.193-235.